

ОЛОН УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ ЧИГЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ХӨГЖЛИЙН ТОЙМ: ЦАГДААГИЙН БОЛОВСРОЛЫН ЖИШЭЭН ДЭЭР DEVELOPMENT FORECAST OF INTERNATIONAL LAW ENFORCEMENT EDUCATION SYSTEM: ILLUSTRATING ON OF POLICE EDUCATION



Б.Одончимэг. ХСИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад
Odonchimeg.B. Senior officer of Academic policy and coordination department, Law Enforcement University, Police captain

Abstract: The article is aiming to define the concerns of university's future development and the impact of the ongoing law and higher education reformation, as well as the impact of global higher education trend on the Law Enforcement University. While studying international law enforcement education providing experiences.

Key word: Law enforcement sector, education system, police education, phased training, Bologna process, credit systema education, International standard classification of education "ISCED2013".

ХСИС байгуулагдсан цагаас бидний өмнө хурдтай шинэчлэгдэх, дасан зохицох, оновчтой шийдвэр гаргах олон нөхцөл тулгарсны нэг нь их сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, чанарыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх асуудал юм. Энэ үйл явцыг нэг талаас боловсролын салбарт, нөгөө талаас аюулгүй байдал, хууль сахиулах орчинд гарч буй хөгжил, шинэчлэлд тулгуурлан хөтлөх нь гарцаагүй.

Олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх нь хөгжлийн хөтөч мөн ч аливаа жишиг, стандарт, заавар, жорыг шууд хуулбарлах нь агуулах савныхаа шинжид тохироогүй эд, идээ хийсэнтэй адил ихдэх, багадаа, эдэх гэм байхыг бас санууштай.

ХСИС-ийн сургалтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх асуудалд бүтээлчээр хандаж, онол, арга зүй, удирдлага, зохион байгуулалтын хувьд үр ашигтай шийдэл гаргахад дөхөм болгох; шууд хуулбарлах алдаанаас сэргийлэх санаагаар олон улсын хууль сахиулах чиглэлийн боловсролын агуулга, сургалтын хэв шинж, дээд боловсролын тогтолцоон дахь өөрчлөлт, шинэчлэлийн талаар цагдаагийн боловсролын жишээгээр тоймлон толилуулья.

Нэг. Олон улсын цагдаагийн боловсролын хөгжлийн тойм

Нийгэмд цагдаагийн байгууллагын эзлэх байр

суурь, гүйцэтгэх үүргийг тодорхойлогч цагдаагийн боловсролын хөгжлийг түүхэн үечлэлээр авч үзсэн судалгаанаас харахад олон улсын хэмжээнд дараах үе шатыг туулсан байна.

1. Цагдаагийн анхан шатны бэлтгэл хангах сургалтын үүсэл, хөгжил (XIX зууны эхнээс XX зууны эхэн). Цагдаагийн албанд шинээр элсэгчдэд зориулсан богино хугацааны сургалтын үе;

2. Цагдаагийн мэргэжлийн боловсролын үүсэл, хөгжил (XX зууны эхэн – 1970-аад он.) Тусгай дунд ба дипломын дээд боловсрол олгох сургалтын үе;

3. Барууны улс орнуудад ардчилсан өөрчлөлтийн дүнд үүссэн "Нийгэм бол худалдан авагч, цагдаагийн байгууллага үйлчилгээ борлуулагч" хэмээх үзэл санааг тусгасан цагдаагийн боловсрол олгох сургалтын үе;

4. Өнгөрсөн зууны 90-ээд оноос олон улсад цагдаагийн албаны сонгон шалгаруулалт ардчилсан шинжтэй, албаны үйл ажиллагаа нь цэргийн хэв шинжээс хөндийрч, өөрийн гүйцэтгэх үүрэг, үзэл баримтлалдаа нийцсэн соёл, уламжлалтай болж эхэлсэн. Үүнтэй уялдан цагдаагийн боловсрол олгох сургалтын үйл явц хүмүүнлэг, оюунлаг хандлагатай, шаталсан тогтолцоотой, цагдаагийн дээд боловсролын агуулга их сургуулийн түвшин, стандарт руу ойртсон, суралцагчдын бүтээлч сэтгэхүй, хувь хүний хөгжлийг хангасан нээлттэй, тасралтгүй хэв шинжтэй, олон улсын хамтын ажиллагаанд

бэлтгэхэд чиглэгдэн хөгжиж байна.

Хөгжингүй улс орнуудад цагдаагийн ажилтнуудыг бэлтгэх боловсролын үйл явц нь дараах нийтлэг онцлогтой. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагаанд оролцогчдын бүх үйлдлүүд яв цав журамлагдсан. /Дэмжих үйлчилгээнийхэн, багшлах бүрэлдэхүүн, арга зүйчид, сонсогчид г.м /
- Төрөл бүрийн заавар, журам, сургалтын гарын авлага, арга зүйн зөвлөмж зэрэг арга зүйн хүчирхэг хангалт бүрдүүлсэн;
- Сургалтын агуулга нь багш суралцагчдад ойлгомжтой, хэрэглээнд түшиглэсэн, оновчтой, богино хугацаанд зайлшгүй эзэмших мэдлэг, чадварын хүрээ нь (accomplishments and skills) тодорхой. Орон нутгийн засаг захиргаа болон цагдаагийн байгууллага нь сургалтад элсэгчдийн сонгон шалгаруулалт, сургалтын байгууллагын удирдлага, санхүүжилт, сургалтын хөтөлбөр, түүний агуулгын боловсруулалтад оролцдог бөгөөд сургууль нь өөрөө иргэдэд нээлттэй, “тунгалаг” байх зарчмыг баримталдаг;
- Сургалтын мэргэшүүлэх хөтөлбөрүүд нь хэрэглээний чиглэлд хөгжсөн бөгөөд бодит сургалтын арга буюу (experiential learning) дүрд тоглох, хэлэлцүүлэг өрнүүлэх, асуудал шийдвэрлэх, харилцан суралцах, симуляц орчинд ажиллах зэрэг аргуудыг өргөн хэрэглэдэг;
- Сэтгэл зүйн таатай уур амьсгал буюу “бүлэг доторхи аюулгүй байдлын мэдрэмж”-ийг бүрдүүлж, хичээл сургалтад өөдрөг хандах, өөртөө, хүч боломждоо итгэх итгэлийг төрүүлдэг ;
- Хичээл, амралтын цагийн тэнцвэрийг хангасан эрчимжүүлсэн сургалтын хуваарьтай;
- Мэдлэг, чадвар, дадлыг хянах хатуу тогтолцоог суралцагчдад итгэх итгэлтэй хослуулдаг;
- Сургалтын бүх үйл ажиллагааны явцад эх оронч хүмүүжил олгоход онцгой анхаарч ажилладаг;
- Сургалт-дадлагын явцад сурган хүмүүжүүлэх өндөр үр дүнтэй технологи ашигладаг (зайны сургалтын технологи, нээлттэй сургалтын технологи г.м.);
- Профессор, багшийн орчин үеийн загварыг сургалтын явцад суралцагчдын оролцоог хангасан бүтээлч менежер буюу суралцагчидтай хамтран (participatory style) сургалтын зорилго, хөтөлбөрөө тодорхойлж, агуулгын хүрээгээ сонгоход оролцуулах үүрэгтэй байхаар тодорхойлсон;
- Профессор, багшийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр бүрдүүлж, сурган-заах арга зүйн мэдлэг, ур чадварт суралцсан байх онцгой шаардлага тавьдаг;
- Багш, суралцагч, дэмжих үйлчилгээ болон төгсөгчид, практик ажилтнуудтай байнгын эргэх холбоо (сэтгэл ханамжийн судалгаа, асуулга г.м)-той байдаг.

Дээрх нийтлэгээс гадна улс орнуудын цагдаагийн

боловсролын тогтолцоо нь тухайн улсын онцлогоос шалтгаалан өөр өөрсдийн өвөрмөц хувилбараар хөгжиж байгаа юм. Тухайлбал, манай хойд хөршийн цагдаагийн боловсролын тогтолцоог бид хамгийн сайн мэдэх тул элдэв тайлбаргүйгээр ерөнхий дүр зургийг судлаачдынх нь баримтад түшиглэн тоймлоё.

ОХУ-ын судлаачдын харьцуулсан судалгаанаас харахад цагдаагийн боловсрол олгох хөтөлбөрийн дийлэнх хувийг онолын гүн гүнзгий агуулга эзэлдэг нь өнөөгийн нийгэм-эдийн засгийн ээдрээтэй, хувьсан өөрчлөгдөж буй өндөр эрсдэлтэй нөхцөлд онолын асар их мэдээллээ хэрэглээнд оруулдаггүй, дасан зохицох, бие даан шийдвэр гаргах, мэргэжлийн үйл ажиллагаагаа зохион байгуулж, хэрэгжүүлэх чадамжгүй онолчдоор цагдаагийн хүний нөөцийг бүрдүүлсэн гэсэн шүүмж түгээмэл .

Соёл иргэншлийн хөгжлийн шинэ үе нь эдийн засгийн үр ашиг болон бүтээлч сэтгэхүйн амьд холбоо, нөгөө талаас хүний өөрийгөө ухамсарлах эрмэлзлэл зэрэг мэдлэгт суурилсан хөгжлийн хуульд нийцүүлэн мэргэжлийн үйл ажиллагаагаа зохион байгуулах хүмүүнлэг сэтгэлгээг цагдаагийн алба хаагчдаас шаардаж байгааг тэмдэглэжээ. Тэд цалин хөлс, нийгэм хангамжийн өсөлт, алба хаагчдын мэргэжлийн аттестатчилал зэрэг олон арга хэмжээ авсан нь ОХУ-ын цагдаагийн байгууллагыг шинэчлэхэд учир дутагдалтай бөгөөд цагдаагийн боловсрол олгох тогтолцоо, түүний үзэл баримтлал, агуулгыг шинэчлэхээс нааш үр дүнд хүрэхгүй хэмээн үзэж байна.

Оросын Холбооны Улсын ДХЯ-ны дэргэд 2012 онд өөрчлөлт, шинэчлэлийн өргөтгөсөн ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгээс “Өөрчлөлт, шинэчлэлтийн замын зураг” боловсруулсны дотор ОХУ-ын ДХЯ-ны харьяа боловсролын байгууллагуудын ажлыг хууль сахиулах албаны журамтай нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтын нэгдмэл, шаталсан тогтолцоог бүрдүүлж, хэрэглээний ур чадварыг дээшлүүлэхэд чиглүүлэн засан сайжруулах, цагдаагийн дунд, дээд түвшний удирдлагын бүтцийг ОХУ-ын ДХЯ-ны их дээд сургууль төгсөгчдөөс шат дараалалтайгаар бүрдүүлэх, ингэхдээ цагдаагийн боловсролын тогтолцоог шаталсан байдлаар хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд орчин үеийн арга барил ашиглах, үр дүнд суурилсан сургалтын хяналт, шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, улмаар ДХЯ-ны сургалтын байгууллагуудыг улсын аттестатчилалд тогтмол хамруулж байх²³² зэрэг цагдаагийн боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн заалтуудыг оруулжээ.

ОХУ цагдаагийн боловсролын одоогийн

²³² Расширенная рабочая группа при Министре внутренних дел Российской Федерации по дальнейшему реформированию органов внутренних дел, “Дорожная карта” дальнейшего реформирования органов внутренних дел Российской Федерации, Москва, 2013

тогтолцоо, хөтөлбөрийн агуулгыг барууны ялангуяа Европын холбооны чиг хандлагатай нийцүүлэн хөгжүүлэх гарц хайж байна.

Европын холбооны улсуудад цагдаагийн боловсрол олгох сургалт нь ерөнхийдөө цагдаагийн байгууллагынхаа бүтэц зохион байгуулалттай нийцсэн, гурван шатны тогтолцоотой. Өөрөөр хэлбэл албан тушаалын зэрэглэл өсөхийн хэрээр мэдлэг, чадварын үзүүлэлт нь албаны үйл ажиллагааны онцлогтой уялдан өсөн нэмэгдэх байдлаар төлөвлөгддөг. Цагдаагийн удирдах албан тушаалын нөөц бүрдүүлэлтэд хамрагдагчид нь эрдмийн зэрэг, ажлын туршлага, цагдаагийн дээд цолоос үл хамааран тухайн албан тушаалын онцлогт нийцсэн агуулга, хугацаагаар хэмжигдэх албан тушаалын (career profile) сургалтад заавал суралцана. Энэ сургалт нь цагдаагийн академи, сургалтын төв болон иргэний боловсролын байгууллагын дэргэдэх цагдаагийн мэргэжилд хамааралтай хөтөлбөрөөр хэрэгждэг. Тухайн сургалтад суралцсанаар доод тал нь цагдаагийн боловсролын бакалавр, (bachelor's level police education), дээд тал нь магистр (master's degree) болон бусад эрдмийн цол эзэмшинэ.

Европын зарим орнуудад цагдаагийн сургалтын байгууллага нь иргэний боловсролын тогтолцооны хүрээнд багтаж, сургалтын үйл ажиллагаандаа тухайн улсын дээд боловсролын стандартыг баримталдаг. Мөн зарим улс оронд удирдах ажилтнаас бусад ажилтнуудыг нарийн мэргэшлийн цагдаагийн анхан шатны сургалтаар бэлтгэдэг. Ерөнхийдөө цагдаагийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, үндэсний болон иргэний боловсролын тогтолцоотойгоо харилцан шүтэлцээтэй байдаг.

Мөн цагдаагийн хүний нөөцийг бэлтгэхдээ олон улсын хамтын ажиллагааны холбоодтой хамтардаг. Энэ үйл явц өнгөрсөн зууны 90-ээд оноос идэвхжсэн бөгөөд ялангуяа дэлхийн хөгжингүй улс орнуудын цагдаагийн хүний нөөцийг бэлтгэдэг шилдэг туршлага дээр тулгуурлан европын нэгдмэл стандартад боловсролын чанараа нийцүүлэх зорилгоор хамтын ажиллагааны холбоо, эвсэл зэрэг олон улсын байгууллагуудыг байгуулсан. Тухайн үед Төв болон Зүүн Европын олонхи улсууд Европын Холбоонд нэгдэх бэлтгэл хангах явцдаа хууль сахиулах байгууллагын тогтолцоогоо эрс шинэчлэх шаардлагатай тулгарсан нь цагдаагийн боловсрол, мэргэжлийн сургалт, бэлтгэлийн тогтолцоог хөндөж, зарим улс орон нь барууны загварыг шууд хуулбарлан зарим нь хуучин тогтолцооны сайн уламжлалуудаа авч үлдсэн байна. Постсоциалист гэгдэх улс орнуудын жишээг Словен улсаар төлөөлүүлэн авч үзье.

Словенд 1995 онд дээд боловсролын салбарт хэрэгжүүлсэн эрх зүйн шинэчлэл нь хэд хэдэн суурь өөрчлөлтийг авч ирсэн юм. Тухайлбал, мэргэжлийн боловсрол болон их сургуулийн боловсролын ялгааг тодорхой болгож, их сургуулийн хөтөлбөр нь их сургуулийн харьяа факультет, академиар, харин

мэргэжлийн дээд боловсрол нь коллежийн бүтцээр хэрэгжиж эхэлсэн байна.

Үүнтэй холбоотойгоор Люблян дахь Цагдаа, аюулгүй байдлын сургалтын коллеж (College of police and security studies-CPSS) нь мэргэжлийн дээд боловсрол олгох байгууллага болон өөрчлөгдөж, Словен улсын дээд боловсролын зөвлөлөөр батлагдсан 3 жилийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус коллеж нь хэсэг хугацаанд мэргэжлийн дээд боловсрол олгох бие даасан байгууллагын хэв шинжтэй байж байгаад шинээр мөрдөж эхэлсэн дээд боловсролын хуулийн дагуу Люблян хотын их сургуулийн салбар болсноор судалгаа, шинжилгээний хүчин чадал болон нийгмийн нэр хүндийг нь өсгөсөн хэрэг болжээ.

Эрдмийн цол, зэрэг олгохдоо Любляны их сургуулийн бүтэц дэх бусад сургуулиудын адил нэгдсэн шалгуур, үзүүлэлт, процедурыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл эрдмийн зэрэг, цол олгох зөвшөөрлийг их сургуулийн зөвлөл шийддэг бол үйл ажиллагааны хувьд ДХЯ-ны бие даасан нэгжийн түвшинд ажилладаг. Иргэний их дээд сургуулийн бааз суурьд түшиглэн бие даасан мэргэжлийн сургалтаар хууль сахиулах байгууллагын хүний нөөцийг бэлтгэдэг энэхүү практик нь АНУ-д өргөн тархсан байдаг.

Тус коллежийн өдрийн ангийн (full-time students) оюутнууд нь 3 жил (6 улирал), эчнээ ангийн оюутнууд нь (part-time students) 4,5 жил (9 улирал) суралцдаг. Сургалтын төлөвлөгөө нь 36 судлагдахуунаас бүрдэнэ. Сургалтын эхний жилд ерөнхий суурь ойлголтууд, 2 ба 3 дахь жилээс мэргэжлийн мэдлэгийн ерөнхий судлагдахууныг судална. Заавал судлах агуулгын хувьд цагдаагийн тактик, менежментийн судлагдахуун голлох байр суурийг эзэлнэ.

Сургалтын эхний 5 улиралд ижил хөтөлбөрөөр суралцах бөгөөд 6 дахь улирлаас дараах 5 мэргэшлийн аль нэгийг сонгон мэргэшиж суралцана. Үүнд: Аюулгүй байдал ба хамгаалалтын тогтолцоо, Иргэний үйл ажиллагаа, Захиргааны үйл ажиллагаа, Цагдаагийн үйл ажиллагаа, Криминалистик, Хувийн аюулгүй байдал зэрэг болно. Сургалт нь коллежийн судалгаа, шинжилгээний төслийн хүрээндэх сэдвээр төгсөлтийн ажил бэлтгэж хамгаалснаар дуусна.

Францад цагдаагийн хүний нөөцийг төвлөрсөн байдлаар сургаж бэлтгэдэг. Цагдаагийн боловсролын тогтолцоо нь дэлхийн хамгийн эртний түүхтэй бөгөөд "дадлагын сургууль" нэртэйгээр 1883 онд байгуулагдаж байжээ.²³³

Францын үндэсний цагдаагийн Ерөнхий удирдлагын бүрэлдэхүүн дэх Цагдаагийн боловсролын захиргаа (La direction de la formation de police nationale - DFPN) нь цагдаагийн мэргэжлийн анхан шатны сургалт, бэлтгэлийг зохион байгуулах ажлыг хариуцдаг. Цагдаагийн анхан шатны бие бүрэлдэхүүнийг 12 сарын турш сургаж бэлтгэдэг

233 <http://www.akadmvd.uz/bibl/police/22.pdf>

байна. Эхний 4 сард цагдаагийн үйл ажиллагаа, ялангуяа эргүүл-хамгаалалтын алба хаахад шаардлагатай суурь мэдлэгүүдийг эзэмшээд, 8 сарын турш цагдаагийн хэлтэст дадлагаар суралцдаг. Цагдаагийн дунд офицерууд 18 сарын сургалтад хамрагдах бөгөөд үүний 1 сар нь аль нэг хотын цагдаагийн газар урьдчилсан бэлтгэлд хамрагдаад, 7 сар Канне-Экюз дэх Үндэсний цагдаагийн офицерын дээд сургуульд суралцана. Дараа нь 3 сар нийслэлийн мөрдөн байцаах газар, дүүргийн эрүүгийн цагдаагийн алба, комиссириатад стажер буюу мэргэжил дээшлүүлэх хэлбэрээр суралцана. Дадлагын дараа 2 сар сургуульдаа суралцаж, шалгалт өгснөөр сургалт дуусна.

Комиссар буюу ахлах офицер бэлтгэх сургалт нь Сен-Сир-О-Мон-д'Ор дахь Үндэсний цагдаагийн дээд сургуульд явагдана. Энэ сургуулийн хөтөлбөр нь цагдаагийн албаны бүх төрлийг хамрах бөгөөд цөөн тооны үндсэн багш нарын хүчээр хэрэгждэг.

Хоёр жилийн сургалтын хөтөлбөрийн цөм агуулга нь сэтгэл судлал, иргэний ба эрүүгийн эрх зүйн судлагдахуунаас бүрдэнэ. Шалгалтыг аман ба бичгийн хэлбэрээр авдаг.

Дадлага нь хотын цагдаагийн газар явагдах ба 3 долоо хоног хэв журмын гвардад, 1 долоо хоног цагдаагийн мэргэжилтэн, 3 долоо хоног цагдаагийн комиссар, 1 долоо хоног ерөнхий тагнуулын мэргэжилтэн, 1 долоо хоног мөрдөн байцаах хэлтсийн мэргэжилтэн зэрэг албан тушаал дээр ажиллана. Хоёр дахь жилийн сургалтаас 2,5 сар хотын цагдаагийн хэлтэст, 1 сар эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст, 1 сар ерөнхий тагнуулын хэлтэст, долоо хоног агаарын болон хилийн цагдаад, долоо хоног үндэсний аюулгүй байдлын ротод, хоёр долоо хоног ажил олгогч ба ажилтны зөрчлийг судалдаг хувийн фирмд, нэг долоо хоног цагдаагийн сургалтын төвд ажилладаг. Эцэст нь сонсогч өөрийн сонголтоор прокурор, хорих байгууллага, засаг даргын тамгын газар, Үндэсний жандармын нэгж зэрэг байгууллагуудад нэг долоо хоног ажиллана. Энэ мэтчилэн албан тушаал ахихын тулд зохих сургалтад хамрагдаж, шалгалтаа амжилттай өгсөн байх ёстой.

Баруун Европын орнуудаас цагдаагийн боловсролын тогтолцооны хувьд хамгийн үр дүнтэй, чанартай сургалт явуулдаг нь ХБНГУ гэж судлаачид үздэг.

Германы цагдаа төвлөрсөн бус бүтэцтэй бөгөөд 16 холбооны улс бүр нь өөр өөрсдийн бие даасан цагдаагийн байгууллага, сургалтын тогтолцоотой. Нийт бие бүрэлдэхүүний 80 хувь нь ахлагч бүрэлдэхүүн бөгөөд тэдэнд цагдаагийн сургууль төгссөн байх шаардлага тавьдаг. 19 хувь нь цагдаагийн дээд боловсролтой дунд офицерууд, 1 хувь нь Цагдаагийн удирдлагын дээд сургууль төгссөн ахлах офицерууд байна.

Цагдаагийн боловсрол олгох шаталсан сургалтын

тогтолцоотой. Үүний эхний шат нь 2,5 жил үргэлжилж, цагдаагийн дунд боловсролын диплом олгож төгсгөдөг анхан шатны сургалт. Дараагийн шат нь 3 жил цагдаагийн дээд сургуульд суралцан цагдаагийн мэргэжлийн боловсрол эзэмшиж, дунд офицерын албан тушаалд ажиллах эрх бүхий дипломтой төгсдөг. Цагдаагийн удирдлагын академид 2 жил суралцаж, цагдаагийн дээд удирдлагын боловсрол эзэмшсэнийг батлах гэрчилгээ олгох сургалт гэсэн шатлалтай. Удирдлагын академийн сургалтад 40-45 хүртэл насны, 10-12 жилийн цагдаагийн албаны туршлагатай, ерөнхий комиссараас дээш цолтой, цагдаагийн дээд сургууль төгссөн боловсролтой алба хаагчдыг суралцуулдаг.

Хойд Рейн-Вестфал мужийн Мюнстер хотод байрлах Цагдаагийн удирдлагын академи нь Герман төдийгүй, Европын Холбооны бусад улсуудын цагдаагийн удирдлагыг бэлтгэх, давтан сургахад голлох үүрэгтэй ажилладаг. Тус сургууль нь 2006 оноос Болоны тунхаглалын зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор нэрээ Цагдаагийн дээд сургууль болгон өөрчилж, сургалтын үйл ажиллагаагаа шинэчилж эхэлсэн. Боловсрол олгох хөтөлбөрүүдээ модуль (төрөл мэргэжлийн 19 модуль) иар боловсруулан суралцагчдын мэдлэг, чадварыг багц цаг буюу кредитээр үнэлж эхэлсэн.

ХБНГУ-ын цагдаагийн боловсрол олгох сургалтын нэг онцлог нь аль ч шатны сургууль төгсөгчдөдөө зөвхөн тухайн сургуулийн боловсролын диплом олгодог. Ингэснээр төгсөгч зөвхөн цагдаагийн байгууллагад ажиллах эрхтэй бөгөөд бусад салбарт хөрвөн ажиллах боломжгүй.

Германы цагдаагийн дээд сургуулийн сургалтын чанарын үнэлгээ, баталгаажуулалтын тогтолцоо нь анхаарал татахуйц хөгжсөнийг энд дурдах нь зүйтэй. Сургалтын чанарын үнэлгээ, баталгаажуулалтыг Кураториум (das Kuratorium) хэмээх тусгай бие даасан нэгж гүйцэтгэх бөгөөд холбооны болон муж улсын төлөөллүүдээс бүрдэнэ. Цагдаагийн дээд сургуулийн захирал нь энгийн иргэн байх бөгөөд сургуулийг удирдлагаар хангаж ажилладаг. Тэрээр кураториумын хуралд зөвлөлдөх эрхтэйгээр оролцоно. Сургалтын чанарын үнэлгээгээр багшлах бүрэлдэхүүний чанарыг хамт олноор нь, удирдлагаар нь, сонсогчдоор нь тогтмол үнэлүүлдэг. Сургалтын үйл ажиллагааны үндэс нь "Сургалтын үйл явц суралцагчийн нүдээр" гэдэг зарчимд суурилна.

Танхимын сургалтын нийт цагийн 25 хувь нь лекц, 25 хувь нь хэлэлцүүлэг, 40 хувь нь дасгал, лаборатори, ажил хэргийн болон дүрийн тоглолтод, 10 хувь нь семинарын хичээлд зарцуулагддаг.

АНУ-ын цагдаагийн байгууллага нь хүний нөөцөө бэлтгэх бие даасан тогтолцоогүй. Иргэний их дээд сургуульд боловсрол эзэмшсэн мэргэжилтнүүдийг татан ажиллуулах бодлого барьдаг. Цагдаагийн академийн өргөн сүлжээ байдаг ч тэд цагдаагийн байгууллагын бүтцэд хамаардаггүй, төсөв санхүүжилт,

удирдлага, зохион байгуулалтын хувьд биеэ даасан бөгөөд иргэний мэргэжилтнүүдийн цагдаагийн үйл ажиллагаа явуулах эрх авах анхан шатны бэлтгэл хангаж өгдөг. Ерөнхийдөө Үндсэн хууль, иргэний эрх зүй, мужийн хууль, тогтоол, тушаал, журам, мөрдөн байцаалт, хуулийн хэрэглээ, сэтгэл судлал, өмгөөлөл, Америкийн түүх, нийтийн удирдлага, англи хэл, эрх зүйн харилцаа, социологи, худалдааны эрх зүй зэргийг судалж, эргүүл, хамгаалалт, замын хөдөлгөөний зохицуулалт, галт зэвсгийн хэрэглээ, бие хамгаалах техник, эрсдэлт нөхцөлд биеэ авч явах дүрэм зэрэгт дадлагаждаг.

АНУ-ын цагдаагийн боловсролын тогтолцоонд тулгамдаж байгаа асуудал нь юуны түрүүнд төвлөрсөн бүтэцгүй, засаг захиргааны олон шатны бие даасан хуулиуд юм. Үүнтэй холбоотойгоор сургалтын байгууллагууд нь тодорхой нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлдэг байгууллагынхаа удирдлагад харьяалагддаг бөгөөд хувийн ба улсын өмчийн олон тооны сургалт, бэлтгэлийн төвүүдтэй. Эдгээрээс хамгийн том нь 1970 онд Жорж мужийн Глинкод 1970 онд байгуулагдсан сургалтын төв бөгөөд хууль сахиулах 70 гаруй байгууллагын алба хаагчдыг богино хугацааны (18 сар хүртэл) сургалтад сургадаг.

Лос-Анжелесийн цагдаагийн академийн сургалтын хөтөлбөрийн 400 цаг нь иргэд, хүн амтай харилцах харилцааны асуудлыг, 360 цаг нь үндэсний цөөнхийн соёлын үндэс, хотын, хөдөлмөрийн болон хувийн харилцааны асуудлыг судлахад зарцуулагддаг.

Ази-Номхон далайн орнуудын цагдаагийн боловсролын тогтолцоо нь АНУ, Европын холбооны аль нэгний чиг баримжааг даган хөгжиж байгаа нийтлэг дүр зурагтай тул тусад нь авч үзсэнгүй. Гэхдээ тус бүс нутгийн болон улс орны онцлогт нийцсэн сайн туршлагууд байгаа нь дамжиггүй.

Дээрх улс орнуудын цагдаагийн боловсролын тогтолцооны өөрчлөлт, шинэчлэл нь тасралтгүй хувьсан өөрчлөгдөж буй байгал-нийгмийн үзэгдэл; мэдээллийн өндөр хурдтай их урсгал; шинжлэх ухаан, боловсролын даяаршлийн дараах үйл явцаар нөхцөлдсөн юм.

Хоёр. Олон улсын дээд боловсролын хөгжлийн чиг хандлага ба Монгол улс

Орчин үеийн дээд боловсролын хөгжлийн даяаршил нь 1999 оноос Европынх дээд сургуулиудын санаачлагаар эхэлсэн “Болоний үйл явц” бөгөөд дээд боловсролын шаталсан тогтолцоо; үнэлгээний нэгдсэн систем; багш, суралцагчдын чөлөөт шилжилт хөдөлгөөн; дипломын хавсралтын нэгдмэл загвар; сургалтын чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд үндсэн зорилтууд нь чиглэдэг.

Болоний үйл явцад одоогоор Европын холбооны 47 улс нэгдсэн бөгөөд 2003 онд ОХУ, 2005 онд Украин, 2010 онд Казахстан улс нэгдсэн байна. Энэ үйл явцад бусад улс орнууд чөлөөтэй

хамрагдаж болно гэсэн заалттай. Монгол улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж 2011 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Европын Холбоо болон түүний гишүүн улсуудаас тус улсад суугаа элчин сайдуудыг хүлээн авч уулзахдаа “Боловсрол, соёлын хамтын ажиллагаатай холбоотойгоор Монгол Улс “Болоний процесс”-т нэгдэх хэрэгтэй байна. Энэ завшааныг ашиглаад хэлэхэд хоёр талын хамтын ажиллагааны хэлэлцэх хэргийн төлөвлөгөөндөө монголын боловсролын үнэмлэхийг Европын Холбооны улсууд хүлээн зөвшөөрөх асуудлыг оруулаасай гэж хүсч байна.”²³⁴ гэдгээ илэрхийлсэн байдаг.

Одоогоор БШУЯ Болоний үйл явц, дээд боловсролын салбарт европын дээд боловсролд баримталж буй нийтлэг шаардлагуудыг нэвтрүүлэх боломжийг судалж байна.

Монгол улсын дээд боловсролын салбарт хийсэн томоохон шинэчлэл нь кредит буюу багц цагийн үнэлгээг нэвтрүүлсэн явдал бөгөөд 1995 онд батлагдсан “Дээд боловсролын тухай хууль”-д анх «кредит цаг» хэмээх ойлголт тусгагдаж, 1998 онд Гэгээрлийн сайдын 225 тоот тушаалаар «Дээд боловсролын зэрэг олгох сургалтад кредит үнэлгээ хэрэглэх, суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэх журам» батлагдсанаар кредит системийг сургалтад хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрэлдэв. Улмаар «Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэхэд баримтлах журам» 2003 онд БСШУЯ-ны сайдын 158 тоот тушаалаар шинэчлэн батлагджээ.

Үнэлгээний багц цагийн загвар нь тухайн улсын дэлхийн дээд боловсролын нэгдсэн тогтолцоонд хамрагдах, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх үндэс юм. АНУ-ын Харвардын их сургуульд 1869 онд хэрэглэж эхэлснээс хойш дэлхийн улс орнууд ялангуяа Болоний үйл явцад нэгдсэн улсууд сүүлийн 10 гаруй жилийн турш дээд боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж байна.

Олон улсын дээд боловсролын тогтолцоонд USCS – багц цагийн Америк загвар; CATS – багц цаг хуримтлуулах, шилжүүлэх Британи загвар; UCTS – Ази и Номхон далайн орнуудад багц цаг шилжүүлэх загваруудыг тус тус хэрэглэж байна.

Хүснэгтээр²³⁵ дэлхий нийтэд хэрэглэж буй багц цагийн үнэлгээний үндсэн загваруудыг харуулав. Багц цагийн үнэлгээний загвараас хамгийн удаан хугацаанд буюу 100 гаруй жил хэрэгжиж байгаа нь Америк хувилбар юм. Доорх хүснэгтэд багц цагийн хуримтлуулах болон шилжүүлэх хувилбарыг харуулсан. Сургалтын ачаалал нь зарцуулах нийт цагийн багтаамж болон танхимын цагаар тодорхойлогдоно. Бакалаврын сургалтын хугацаанд

²³⁴ <http://www.president.mn>

²³⁵ Байм В.В., Чистохвалов В.Н., Филиппов В.М., Система зачетных единиц (кредитов) как один из инструментов признания квалификаций: Учеб. пособие. – М.: РУДН, 2008.

цуглуулах нийт багц цаг нь 120-360-ын хооронд, нэг улиралд ноогдох багц цаг нь 15-60 –ын хооронд тус тус хэлбэлзэнэ. Манай улсын дээд боловсролын тогтолцоонд хэрэглэж байгаа багц цагийн үнэлгээний загвар нь USCS – USCredit System буюу Америк хэв шинжтэй.

Нэр	Эхэлсэн хугацаа	Хэрэглээний тархалт	Зорилго	Үнэлгээний онцлог	Тооцох нэгж	Бакалаврын түвшний багц цаг хуримтлуулах хугацаа	Нэг улиралд ноогдох багц цаг
USCS – USCredit System	1869	АНУ, Канад, Латин Америкийн орнууд Филиппин Таиланд, Индонез, Нигер, Лесото	Суралцагчдын академик эрх чөлөөг хангах	Багц цагийн үнэлгээний хуримтлал	Танхимын 120 багц цаг	4 хичээлийн жил	15
ECTS European Credit Transfer System	1987	Баруун, Төв, Дорнод Европын орнууд	Суралцагчдын академик шилжилтийг хангах	Багц цагийн үнэлгээний шилжилт	Ерөнхий 180-240 багц цаг	3-4 хичээлийн жил	30
CATS – Credit Accumulation and Transfer System	1990-ээд оны эх	Их Британи улсын үндэсний тогтолцоо	Суралцагчдын академик эрх чөлөө, шилжилтийг хангах	Багц цагийн үнэлгээний хуримтлал, шилжилт	Ерөнхий 360	3 хичээлийн жил	60
UMAP- University Mobility in Asia and the Pacific	1993	Австрал, Бруней, Сингапур, Камбож, Япон, Монгол зэрэг улсуудад нээлттэй	Суралцагчдын академик шилжилтийг хангах	Багц цагийн үнэлгээний шилжилт	Ерөнхий 240	4 хичээлийн жил	30

Үүний зэрэгцээ ЮНЕСКО-гийн шинэчлэн боловсруулсан /International standard classification of education “ISCED-2013”/ Боловсролын олон улсын ангиллын стандартад нийцүүлэн дээд боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүдийн нэр, индексийг шинэчлэх ажил эрчимтэй явагдаж, энэхүү өгүүллийг бичиж байх хугацаанд буюу 2013 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн БШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлах тухай” А/87 тушаал батлагдлаа.

ЮНЕСКО-гийн “ISCED-2013” стандарт нь НҮБ-ын гишүүн орнуудын хэмжээнд хэрэгжүүлж буй дээд боловсролын хөтөлбөрүүдийн нэр, индексийг 11 ерөнхий чиглэл, 29 төрөл чиглэл, 80 нарийвчилсан чиглэлээр нэгтгэж, дээд боловсролын тогтолцоонд нүүрлээд байгаа сургалтын хөтөлбөрийн хэт нарийсалт; хөрвөх, харилцан хүлээн зөвшөөрөх боломжгүй мэргэжил; хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлага хангахгүй төгсөгчид зэрэг асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

БШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индексийг

шинэчлэн батлах тухай” А/87 тушаалаар бакалаврын мэргэжлийн 10 ерөнхий чиглэл, 27 төрөл чиглэл, 83 нарийвчилсан чиглэл, 188 хөтөлбөрийн нэр индекс батлагдсан байна. Хууль сахиулах чиглэлийн бакалаврын мэргэжлийн хөтөлбөрүүд дараах байдлаар нэршиж, индекслэгдсэн.

- Ерөнхий чиглэл: **10** *службы services* үйлчилгээ
- Төрөлжсөн чиглэл: **103** *службы безопасности security services* аюулгүй байдлыг хангах үйлчилгээ
- Нарийвчилсан чиглэл: **1032** *охрана граждан и собственности protection of persons and property* Иргэн, өмч хөрөнгө хамгаалал
- Салбар дундын хөтөлбөр: **1038** *междисциплинарная программа службы безопасности, inter-disciplinary programmes and qualifications involving security services*, Аюулгүй байдлыг хангах үйлчилгээтэй холбоотой салбар дундын хөтөлбөр.

Олон улсын дээд боловсролын салбарт явагдаж байгаа бас нэгэн чухал шинэчлэл бол боловсролын

чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх үйл явц юм. Энэ үйл явцыг санаачлан манлайлагч Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын европын холбоо (*European Association for Quality Assurance in Higher Education, ENQA*) нь 2000 онд Хельсинк хотноо Болоний тунхаглалд нэгдсэн улс орнуудын оролцоотойгоор байгуулагджээ. Өнөөдөр олон улсын хэмжээнд боловсролын чанарын баталгаажуулалтыг хангах төрөл бүрийн загвар боловсруулагдаж, аттестатчилал, шинжилгээ-үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг төрийн ба төрийн бус байгууллагын статустай институциуд олноороо бий болсон байна.

Ямар ч салбарын хүрээнд чанарын баталгаажуулалт гэдэг нь байгууллагад болж буй процесстэй холбоотой ойлголт юм. Сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусгасан эрхэм, зорилго, зорилтыг хангасан байдлыг чанар гэнэ.²³⁶

Чанарт хяналт-шинжилгээ хийж, түүнийг баталгаажуулах нь тухайн байгууллагын бүтээгдэхүүн сайн чанартай байхаар процесс, системийг боловсруулж, хэрэгжүүлэхийг нөхцөлдүүлнэ. Энэ бол байгууллагыг бэхжүүлэх, хөгжүүлэхэд ашигладаг албан ёсны менежментийн систем.²³⁷ Чанарын баталгаажуулалтыг хөндлөнгийн ба дотоод үйл явцаар хангадаг.

Манай улсын хувьд Дээд боловсролын чанарын баталгаажуулалтыг хангах хөндлөнгийн үйл явцыг харьцангуй бие даасан систем бий болгох суурийг 15 жилийн өмнө тавьсан нь БМИҮЗ юм. Чанарын баталгаажуулалтыг хяналт шалгалттай хольж хутгах, давхардсан олон үр ашиггүй шалгалтуудаар дарамт үүсгэх, хөгжүүлэх бус шийтгэх хандлага байгааг Дээд боловсролын шинэчлэлийн төслийн зөвлөхүүд тэмдэглэсэн.

Цаашид их дээд сургуулиудын дотоод чанарын баталгаажуулалтын үйл явцыг тогтворжуулах, хөгжүүлэх, бэхжүүлэх талаар БШУЯ, АХБ-ны ДБШТ, БМИҮЗ идэвхтэй хамтран ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

ХСИС нь дээд боловсролын байгууллагын хувьд сургалтын хөтөлбөр, агуулга, чанарыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар дараах алхамуудыг хийсэн.

1. ХСИС-ийн сургалтыг шаталсан, нэгдмэл

²³⁶ AUN: Quality assurance, Manual for the implementation of the Guidelines, Bangkok 2006

²³⁷ "Internal Quality assurance of HEIs" сургалтын материалаас, Азийн хөгжлийн банкны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн олон улсын зөвлөх, Магадлан итгэмжлэлийн олон улсын зөвлөх, ОУДБЧБХ-ны дэд ерөнхийлөгч, НҮБ-ийн шинжээч Сузанна Караханян, Дээд боловсролын шинэчлэл төслийн чанарын баталгаажуулал, магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан үндэсний зөвлөх, Р. Бат-Эрдэнэ, Ph.D

тогтолцоогоор зохион байгуулсан нь олон улсын хууль сахиулах чиглэлийн боловсролын тогтолцооны одоогийн хөгжилтэй нийцэж байгаа бөгөөд хүн ам, ажиллах хүч, материаллаг нөөцөнд тохирсон, мэдлэгийн нэвчилт, солилцоо, хууль сахиулах чиглэлийн байгууллагуудын багаар хамтран ажиллах, харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандах, улмаар нэгдмэл зорилгын төлөө эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх хамгийн үр ашигтай хувилбар гэж үзэж байна.

2. Профессор багшийн ажил үйлчилгээ, суралцагчийн мэдлэг, чадварыг багц цагаар үнэлэх журмыг өмнөх бүтцийн үед хэрэглэж байсан журмаас сайжруулж, багшийн олон талт ажлуудыг үнэлгээнд оруулах, нийт багц цагийн дотор танхимын ба бие даалтын сургалтын цагийн харьцааг ялган тодорхойлж, барууны улс орнуудад түгээмэл хэрэглэгдэж буй бие даалтын сургалт, суралцагчдын оролцоог түлхүү хангасан семинар, дасгал, лаборатори, багийн удирдлага доорхи бие даалт зэрэг танхимын сургалтын хичээлийн цагийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн суралцагчдын үнэлгээг илүү нарийвчлалтай болгосноор суралцагчдын хариуцлага, өрсөлдөх чадварын мэдрэмжийг дээшлүүлж, сурлагын чанарын чансааг тодорхойлох боломжийг нэмэгдүүлэх үр дүнг хүлээж байна. Голч дүнгийн үзүүлэлтийг албан ёсоор үнэлгээнд оруулснаар суралцагчдын судалсан агуулга, түүний үнэлгээг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл бүрдүүлсэн.

3. Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар, бие даалтын сургалтын заавар зэргийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласнаар сургалтын агуулгад багш хариуцлагатайгаар судлаачийн байр сууринаас бүтээлчээр хандах нөхцөлийг бүрдүүлэх оролдлого хийсэн.

4. Өөрийн үнэлгээний тайлан бичих заавар, профессор багшийг аттестатчилж, тэнхим бүрэлдэхүүн сургуулийн чансаа тогтоох журам боловсруулан хэрэгжүүлснээр сургалтын үйл ажиллагааны чанарт өөрсдөө үнэлгээ хийх, зөв ажиллаж байгаа эсэхээ тодорхойлоход суралцаж, цааш хөгжих гарцаа харж, сайжруулах асуудлаа тодорхойлох боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

4. ЮНЕСКО-гийн "ISCED-2013" стандартаар мэргэжлийн хөтөлбөрүүдийн нэр, индексийг боловсруулан 7 ерөнхий хөтөлбөрийн нэр, индексийг батлуулсан. БШУЯ-ны дээд боловсролын чанарын шинэчлэлийн бодлогын танилцуулгад "Элсэлтийг батлагдсан хөтөлбөрөөр аваад сүүлийн 2 жилд мэргэшүүлнэ" гэсэн байгаатай бидний эхэлсэн ажил нийцэж байна. Тухайлбал, дээд боловсролын болон мэргэжлийн суурь агуулгыг ерөнхийд нь ижил төстэй судлуулаад мэргэшлийн суурь агуулгад суралцагчдын сонгон шалгаруулж суралцуулах ажлыг эхлүүлсэн.

Дээрх эхлүүлсэн ажлууд ХСИС-ийн сургалтыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх анхны

алхамууд бөгөөд бидэнд зорих зорилго, хийх ажил их байна. Юуны түрүүнд дараах ажлуудад анхаарлаа хандуулах шаардлагатай.

1. Мэргэжлийн хөтөлбөрийг шинэ нэр, индексээр, БШУЯ-наас батлагдан гарах хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу чанартай боловсруулах, боловсруулалтад сонирхогч тал буюу агентлаг байгууллага, төгсөгч, багш, суралцагчдыг татан оролцуулах нөхцлийг бүрдүүлэх

2. Мэргэжлийн хөтөлбөрүүдийн агуулгыг эрх зүйн шинэчлэл буюу хууль сахиулагчдын үндсэн чиг үүрэг, үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх. Тухайлбал хүний эрх, эрх чөлөөг дээдлэн, үндэсний эрх ашгийг хангасан хууль сахиулах үйлчилгээ үзүүлэх хандлагыг хөтөлбөр бүрийн зорилгод тусгах, шаталсан сургалтын түвшин бүрт хэрэглээний болон академик агуулгын харьцааг оновчтой тогтоох

3. ХСИС-ийн үндсэн чиг үүрэг буюу сургалтын үйл ажиллагааны чанар, стандартыг баталгаажуулах, чанараа тасралтгүй сайжруулах стратеги, бодлого, процедураа боловсруулан албажуулж, олон нийтэд нээлттэй, сонирхогч бүх талуудын оролцоог хангасан дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэн, хөгжүүлэх

4. Хууль сахиулах чиглэлийн боловсролын


асуудлаар олон улсын байгууллага, нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллаж, олон улсад танигдах зэрэг саналтай байна.

Ашигласан эх сурвалж

1. U.S. Department of Labor, Bureau of Labor Statistics, *Occupational Outlook Handbook*, <http://www.bls.gov/ooh/Protective-Service/Police-and-detectives.htm> (accessed December 6, 2012).
2. National Center for Educational Statistics, *Tuition Costs of Colleges and Universities*, under "Fast Facts," <http://nces.ed.gov/fastfacts/display.asp?id=76> (accessed December 6, 2012).
3. Robert Friedman, "University Perspective: The Policing Profession in 2050," *Police Chief*, August 2006.
4. Higher Education and Local Law Enforcement By Susan Hilal, Ph.D., and James Densley, Ph.D. 5/7/2013
5. Профессиональная подготовка руководящих кадров полиции в странах европы: особенности и тенденции развития., Кобозев А.А., Монгуш А.С.
6. <http://www.uis.unesco.org/Education/Documents/iscsd-37c-fos-review-222729r.pdf>, Пересмотр Международной стандартной классификации образования: области образования и подготовки (МСКО-Ф)

ХСИС-ИЙН ДИДАКТИКИЙН ШИНЭЧЛЭЛ: ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

DIDACTICS REFORM OF LAW ENFORCEMENT UNIVERSITY: METHODOLOGY TO DEVELOP EVALUATION ASSIGNMENT



Т.Азжаргал. ХСИС-ийн Ерөнхий Эрдмийн Сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

Azjargal.T. Lecturer of Public Administration Faculty, Institute of General disciplines, Law Enforcement University, Senior Lieutenant

Abstract: Education policies of the universities and institutes focus toward implementing appeals of "New study" method and it has spent considerable time since "rules and tools" of subsequent occupation and preparation to other sectors of life have become contemporary high education trend of the world more than a method that teacher provides education and knowledge to students. The reason is that at present educational training which can hold balance between "science orientation" and "practical orientation" occupies the significant position.

Throughout Mongolia, an appeal which means "Reform of legal sector could be a complex reform" is implemented and accordingly a complex reform to be implemented in its structural and institutional level is still continued by a curriculum reform of the Law Enforcement University. Therefore at present, we need to conduct